



САНГИЙН САЙД Ч.УЛААН  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 151. ЧАТ-САД/2013/СГА-5КНД

**Валютын ханшийн зөрүүг  
тусгах тухай**

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар Оюутолгой ХХК-иас Урьдчилгаа төлбөрийн гэрээгээр авсан 150.0 сая ам.долларын валютын ханшын зөрүүг тусгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Санхүүгийн тайлан гаргахдаа гадаад валютаар хийсэн орлого, зарлагыг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн Монголбанкнаас зарласан ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлж бүртгэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “.... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

1. Оюутолгой ХХК-иас авсан 150.0 сая ам.долларын 2012 оны 12 дугаар сарын 31-ний 15,102,000,000 төгрөгийн валютын ханшийн зөрүүг бүртгэлд тусгах.
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2013 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ариунсанаа нарт хариуцуулав.

АУДИТОР



Р.ЦОЛМОН